



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/538

Эрдэнэт

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/a/ , 29.2 , Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит 4 дүгээр хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2017 оны 10 дугаар сарын 06-08-ны өдрүүдэд АНУ-ын Вашингтон хотод болох Залуу удирдагч бага хуралд оролцох Боловсрол, соёл, урлагийн газрын мэргэжилтэн Дагвадоржийн Отгонбаатарт 2500000 /Хоёр сая таван зуун мянган/ төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Шаардагдах зардал 2500000 /Хоёр сая таван зуун мянган/ төгрөгийг Засаг даргын нөөц сан хуваарилагдаагүй бусад зардлын жагсаалтын “Боловсрол, эрүүл мэнд, спорт, урлагийн салбарын ажиллагсдын мэргэжил дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх” арга хэмжээний зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ